



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

Зочид буудал, амралтын газрын
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батхаан групп ХХК-ийн “Батхаан” зочид буудлын 17/209, Сити тоувер хотел ХХК-ийн “Хөвсгөл лейк хотел” зочид буудлын 18/101, Багануур сувилал ХХК-ийн “Уурхайчин” зочид буудлын 17/170 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.


4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.


5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг

1150500328


үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Х.Содномдэмбэрэл/-
д үүрэг болгосугай.

б. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас
хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн
гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан
бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА  Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 12
сарын 07 өдрийн А/93 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.12.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Батхаан групп ХХК	2027963	Батхаан	БГД-ийн 1-р хороо, Замчдын гудамж 37
2	Эм Би Тур ХХК	6182178	Хөвсгөл лейк хотел	СБД-ийн 8-р хороо, Бага тойруу 14200
3	Багануур сувилал ХХК	2009439	Уурхайчин	БНД-ийн 3-р хороо, Нацагдоржийн гудамж, Багануур сувилал ХХК

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 12
сарын 07 өдрийн А/93 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284925 СБТ 4 2976 1118262502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.12.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Тэрэлж стар ХХК	5235545	Тэрэлж стар ресорт	Налайх дүүрэг, ГТБЦГ, Өвөр хүүшийн ам